



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/394

Улаанбаатар хот

Нийтийн сонсгол зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийтийн сонсголын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 9 дүгээр зүйлийн 9.3.2, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, дүүргийн 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн төслийг олон нийтэд танилцуулах зорилгоор нийтийн сонсголыг 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т даалгасугай.

2. Нийтийн сонсгол зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төлөвлөгөөг баталж, шаардагдах зардлыг Тамгын газрын төсөвт зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, эргэн танилцуулж ажиллахыг Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ